

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2024 оны ... сарын ...-ны ... тоот
тушаалын ... дугаар хавсралт*



ИНД - 143

**Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн
байгууллагын гэрчилгээжүүлэлт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-143 нь агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын гэрчилгээжилтэд тавигдах шаардлагыг тогтооно.

Энэхүү дүрэмд агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг олгох, зөвшөөрөл олгогдсон тухайн Нислэгт Тэнцэх Чадвар Хадгалалтын Менежментийн Байгууллага (НТЧХМБ) –ын үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд тусгагдсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	3
143.1. Зорилго	3
143.3. Нэр томъёо ба товчлол.....	3
В Бүлэг - Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагад зөвшөөрөл олгох	5
143.51. Зөвшөөрөл авах хүсэлт гаргах.....	5
143.52. Зөвшөөрөл олгох.....	5
143.53. Зөвшөөрлийн гэрчилгээ олгох.....	6
143.55. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын давуу эрх	6
143.57. Зөвшөөрөл олгох нөхцөл.....	6
С Бүлэг - Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын өөрчлөлт	8
143.101. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагад онцлох өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх хүсэлт гаргах	8
143.103. Онцлох өөрчлөлтийг зөвшөөрөх.....	8
143.105. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын онцлох биш өөрчлөлт.....	8
143.107. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын ерөнхий зааварт өөрчлөлт оруулахыг шаардах.....	8
Д Бүлэг - Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагад тавигдах шаардлага	10
143.151. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн Ерөнхий заавар.....	10
143.153. Байгууламж болон тоног төхөөрөмж	10
143.155. Гүйцэтгэх захирал	10
143.157. Нөөц	11
143.159. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер	11
143.161. Чанарын менежер	12
143.162. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн ажилтнууд.....	12
143.165. Нислэгт тэнцэх чадвар дүгнэх ажилтан.....	13
143.167. Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах ажилтан	13
143.169. Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын зааварчилгаа	15
143.171. Техник үйлчилгээний өгөгдөл.....	15
143.172. Чанарын тогтолцоо	16
143.173. Дотоод хяналт	17
143.175. Бүртгэл хөтлөх	17
Е Бүлэг - Батлагдсан найдвартай ажиллагааны хөтөлбөрийн шаардлагууд	18
143.201. Ерөнхий шаардлагууд.....	18
143.203. Хөтөлбөрийг тодорхойлох, хэрэглэх боломж.....	18
143.205. Хөтөлбөрийн зорилго.....	18
143.207. Нөөц	18
143.209. Өгөгдөл цуглуулах	18
143.211. Гүйцэтгэлийн стандартууд.....	19

143.213.	Мэдээллийг харуулах	20
143.215.	Мэдээллийн дүн шинжилгээ, тайлбар	20
143.219.	Шинжлэн шалгах, залруулах арга хэмжээ.....	20
143.221.	Хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт	21
143.223.	Өгөгдлийг нэгтгэх	21
F Бүлэг - Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагуудад тавигдах шаардлага, зөрчил	22	
143.301.	Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээний нөхцөл.	22
143.303.	Ажилтнуудыг ерөнхий заавраар хангах.....	22
143.307.	Зааврыг дагаж мөрдөх.....	22
143.309.	Гэрээний дагуу мэдээлэл өгөх.....	22
143.311.	Дүрмийг зөрчсөн тухай мэдэгдлийг даргад хүргүүлэх.....	22

А Бүлэг - Ерөнхий зүйл

143.1. Зорилго

Энэ дүрмээр, Нислэгт Тэнцэх Чадвар Хадгалалтын Менежментийн Байгууллага (НТЧХМБ)-ын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хамаарах дараах шаардлагыг тогтооно. Үүнд:

- (1) НТЧХМБ-ыг гэрчилгээжүүлэх шаардлага; болон
- (2) НТЧХМБ-д тавигдах үйл ажиллагааны шаардлага.

143.3. Нэр томъёо ба товчлол

(а) Энэхүү дүрэмд:

нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын гүйцэтгэх албан тушаалтан гэж тухайн байгууллагаас томилогдсон, дараах асуудлыг хариуцах этгээдийг хэлнэ.

- (1) тухайн байгууллага өөрийн заавар, зөвшөөрөл болон энэ дүрмийг дагаж мөрдөж буйг бататгах;
- (2) тухайн байгууллага өөрийн зааварт заасан нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээг санхүүжүүлэх боломжтойг бататгах; болон
- (3) тухайн байгууллага өөрийн зааврын дагуу нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх хангалттай нөөцтэй эсэхийг бататгах.

гэрчилгээ гэж энэ дүрмийн 143.53-д заасны дагуу олгосон гэрчилгээг.

нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ гэж агаарын хөлөгт хамааралтай дараах үйлчилгээг:

- (1) ИНД-119.61 (Техник үйлчилгээний журам)-д дурдсан нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментэд тавигдах шаардлага болон нислэгт тэнцэх чадвар хадгалалтын бүртгэлд тавигдах шаардлага хангагдаж буйг бататгах;
- (2) ИНД-43-ын D бүлэг (Нислэгт тэнцэх чадварын дүгнэлт) дагуу нислэгт тэнцэх чадварын дүгнэлт хийх;
- (3) ИНД-43-ын D бүлэг (Нислэгт тэнцэх чадварын дүгнэлт) дагуу нислэгт тэнцэх чадварын дүгнэлтийг баталгаажуулах;
- (4) ИНД-119.63 (Техник үйлчилгээний хөтөлбөр)-т тусгагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах

нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер гэж тухайн байгууллагад нислэгт тэнцэх чадвар хадгалалтыг хариуцсан, тухайн байгууллагаас томилогдсон этгээдийг.

заавар гэж ИНД-143.52-т заасны дагуу тухайн байгууллагатай холбоотой Даргын баталсан баримт бичгийг.

чанарын менежер гэдэг нь тухайн байгууллагаас томилогдсон, байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог хариуцсан этгээдийг.

онцлох өөрчлөлт гэдэг нь дараах өөрчлөлтүүдийн аль нэгийг хэлнэ:

- (1) байгууллагын нэр өөрчлөгдсөн;

(2) НТЧХМБ-ын байгууламжийн байршилд өөрчлөлт оруулах, үүнд шинэ байгууламж нэмэх;

(3) боловсон хүчний өөрчлөлт:

(i) байгууллага дахь Гүйцэтгэх Захирал; эсхүл

(ii) байгууллагын аль нэг Удирдах ажилтан; эсхүл

(iii) байгууллагын Нислэгт Тэнцэх Чадвар Хадгалалтын Менежер (хэрэв байгаа бол); эсхүл

(iv) байгууллагын Чанарын Менежер (хэрэв байгаа бол);

(4) өөрчлөлт:

(i) байгууллагын нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг агаарын хөлгийн төрөл, загвар; эсхүл

(ii) байгууллагын агаарын хөлгийн маяг, загвар тус бүрээр үзүүлж буй нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээний төрлүүд;

(5) байгууллагын нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээг үзүүлэх боломжид сөргөөр нөлөөлж болох, байгууламж, тоног төхөөрөмж, журам, боловсон хүчинд гарсан өөрчлөлт.

В Бүлэг – Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагад зөвшөөрөл олгох

143.51 Зөвшөөрөл авах хүсэлт гаргах

(a) Аливаа этгээд НТЧХМБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлтийг Даргад гаргана.

(b) Хүсэлт гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байх ёстой:

(1) МСАА00/00 маягтыг бөглөх; ба

(2) хүсэлт гаргагчийн Гүйцэтгэх Захирлаар ажиллаж байгаа эсхүл ажиллах этгээд гарын үсэг зурсан байна.

(c) Хүсэлтэнд дараах зүйлүүд багтсан байх ёстой:

(1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааврын хуулбар;

(2) НТЧХМБ-ыг удирдах, санхүүжүүлэх эрх бүхий Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон этгээдийн мэдээлэл;

(3) байгууллагын Нислэгт Тэнцэх Чадвар Хадгалалтын Менежерийн албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн мэдээлэл;

(4) байгууллагын Чанарын Менежерийн албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн мэдээлэл;

(5) хүсэлт гаргагчийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх агаарын хөлгийн маяг болон загвар;

(6) байгууллагын агаарын хөлгийн маяг, загвар тус бүрээр үзүүлж буй нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээний төрлүүд.

143.52 Зөвшөөрөл олгох

(а) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, Дарга хүсэлт гаргагчийг НТЧХМБ гэж зөвшөөрөх эрхтэй:

- (1) хүсэлт гаргагч нь энэхүү Дүрэмд холбогдох шаардлагуудыг хангасан байх; ба
- (2) хүсэлт гаргагч нь байгууламж, тоног төхөөрөмж, програм хангамж, боловсон хүчин, нислэгт тэнцэх чадвар хадгалалтын заавартай:
 - (i) хүсэлт гаргагчийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээнд тохирсон; болон
 - (ii) энэ Дүрэмд заасан шаардлагыг хангасан; болон
- (3) хүсэлт гаргагч нь тухайн байгууллагын Гүйцэтгэх захирлын албан тушаалд этгээдийг томилсон; болон
- (4) нөөц
- (5) хүсэлт гаргагч нь тухайн байгууллагын нислэгт тэнцэх чадвар хадгалалтын удирдах ажилтаны албан тушаалд аливаа этгээдийг нэр дэвшүүлсэн; болон
- (6) хэрэв хүсэлт гаргагч нь чанарын удирдлагын тогтолцоотой байх шаардлагатай бол:
 - (i) хүсэлт гаргагч нь тухайн байгууллагын Чанарын менежерийн албан тушаалд аливаа этгээдийг нэр дэвшүүлсэн; болон
 - (ii) Чанарын менежерийн албан тушаалд нэр дэвшсэн хүнийг Гүйцэтгэх захирал, Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежерийн (хэрэв байгаа бол) албан тушаалд давхар нэр дэвшүүлээгүй; болон
- (7) (3) ба (5)-д дурдсан албан тушаалд нэр дэвшсэн хүн бүр тохирох зөв хүн байх

(б) Хэрэв Дарга хүсэлт гаргагчийг НТЧХМБ гэж зөвшөөрөхөөр шийдсэн бол, Дарга дараах зүйлийг тодорхойлох ёстой:

- (1) хүсэлт гаргагчийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн агаарын хөлгийн маяг, загвар; болон
- (2) хүсэлт гаргагчийн зөвшөөрөгдсөн агаарын хөлгийн маяг, загвар тус бүрээр үзүүлэх нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээний төрлүүд; болон
- (3) зөвшөөрөлд хамаарах аливаа хязгаарлалтууд.

(с) хүсэлт гаргагчид зөвшөөрөл олгохдоо, Дарга мөн хүсэлт гаргагчийн Ерөнхий зааврыг батална.

143.53 Зөвшөөрлийн гэрчилгээ олгох

(а) Хэрэв Дарга нь хүсэлт гаргагчид НТЧХМБ-ын зөвшөөрөл олговол, Дарга нь Дүрмийн 143.52(б)-д дурдсан зүйлсийг тусгасан гэрчилгээг олгох ёстой.

(б) Даргын олгосон гэрчилгээнд Даргын тогтоосон зөвшөөрлийн гэрчилгээний дугаар багтсан байх ёстой.

(с) Хэрэв Дарга Дүрмийн 143.103-т заасны дагуу НТЧХМБ-д өөрчлөлт оруулахыг зөвшөөрвөл, Дарга тухайн байгууллагад шинэ гэрчилгээ олгож болно.

143.55 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын давуу эрх

НТЧХМБ нь зөвшөөрөгдсөн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээг үзүүлнэ.

143.57 Зөвшөөрөл олгох нөхцөл

Энэ нь НТЧХМБ-ыг зөвшөөрөх нөхцөл юм:

- (1) байгууллага нь дараах шаардлагыг үргэлж дагаж мөрдөх ёстой:
 - (i) түүний Ерөнхий заавар; болон
 - (ii) зөвшөөрөлд хамаарах аливаа хязгаарлалтыг багтаасан түүний зөвшөөрөл; болон
 - (iii) энэ Дүрэм; болон
- (2) байгууллага нь ажилчдаа (1)-д заасан шаардлагуудыг үргэлж дагаж мөрдөж байгааг бататгана.

С Бүлэг – Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын өөрчлөлт

143.101 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагад онцлох өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх хүсэлт гаргах

- (a) Хэрэв НТЧХМБ нь онцлох өөрчлөлт оруулах гэж байгаа бол тухайн байгууллага Даргад өөрчлөлтийг хүлээн зөвшөөрүүлэхээр хүсэлт гаргана.
- (b) Хүсэлтэнд дараах зүйлс тусгагдана:
 - (1) хүсэлтийг бичгээр гаргасан байх; ба
 - (2) санал болгож буй өөрчлөлтийг тодорхой дурдсан байх; ба
 - (3) тухайн өөрчлөлтийн улмаас Ерөнхий зааварт орох өөрчлөлтийн санал бүхий, зааврын тухайн хэсгийг хавсаргах
- (c) Дараах нөхцлийг харгалзан, хүсэлтийг өөрчлөлт хийхээс өмнө гаргана.
 - (1) өөрчлөлт нь Дүрмийн 143.3(b)(3) заалтад дурдсан төрлийн өөрчлөлт бол; болон
 - (2) байгууллага өөрчлөлтийг хийхээс өмнө 7-гоос багагүй хоногийн дотор (b) заалтын дагуу хүсэлт гаргах.

143.103 Онцлох өөрчлөлтийг зөвшөөрөх

- (a) Хэрэв Дарга, НТЧХМБ-д онцлох өөрчлөлт оруулсны дараа, НТЧХМБ-д Дүрмийн 143.52(a)-д дурдсан шаардлага хангагдсан хэвээр байна гэж үзвэл, НТЧХМБ-ын онцлох өөрчлөлтийг зөвшөөрнө.
- (b) Дарга онцлох өөрчлөлтийг батлахдаа хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт оруулсан холбогдох өөрчлөлтийг мөн батлана.

143.105 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын онцлох биш өөрчлөлт

(a) НТЧХМБ-д оруулах онцлох биш өөрчлөлтийг тухайн байгууллагын Ерөнхий зааварт заасан журмын дагуу хийх ёстой.

(b) Хэрэв ийм өөрчлөлт хийсэн бол байгууллага өөрчлөлт хийснээс хойш 28 хоногийн дотор:

- (1) Ерөнхий зааврыг шинэчлэх; ба
- (2) өөрчлөлтийн талаар бичгээр үйлдэн, Ерөнхий зааврын шинэчилсэн хэсгийн хуулбарын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.

143.107 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагын Ерөнхий зааварт өөрчлөлт оруулахыг шаардах

(a) Дарга нь НТЧХМБ-ын Ерөнхий зааварт өөрчлөлт оруулахыг шаардаж болно:

- (1) Ерөнхий заавраас тодорхой мэдээллийг хасах; эсхүл
- (2) Ерөнхий зааварт тодорхой мэдээлэл оруулах; эсхүл
- (3) Ерөнхий заавар дахь мэдээллийг засварлах, өөрчлөх.

(b) Ерөнхий заавар нь энэ Дүрэмд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд шаардлагатай гэж үзвэл Дарга энэ Дүрмийн дагуу өөрчлөлт оруулахыг шаардана.

(c) Энэхүү шаардлага нь:

- (a) бичгээр байх; болон
- (b) шаардлагыг дагаж мөрдөх хугацааг зааж өгнө

D Бүлэг – Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагад тавигдах шаардлага

143.151 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн Ерөнхий заавар

(a) НТЧХМБ нь дараах мэдээллээс багагүй мэдээллийг агуулсан Ерөнхий заавартай байх ёстой:

- (1) НТЧХМБ нь тогтмол энэхүү Дүрэм болон Ерөнхий зааврын дагуу нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээг үзүүлэхийг бататган Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл;
- (2) НТЧХМБ-ын зөвшөөрөгдсөн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээний нарийвчилсан хамрах хүрээ;
- (3) дараах албан тушаалыг хашиж буй хувь хүмүүсийн нэрс
 - (i) Гүйцэтгэх захирал;
 - (ii) Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер ба түүнийг орон гүйцэтгэх аливаа менежер;
 - (iii) Удирдах албан тушаалтнууд;
 - (iv) Чанарын менежер;
- (4) НТЧХМБ-ын ажилчдын үүрэг хариуцлагын хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) Дүрмийн 143.153-д заасны дагуу байгууллагын үйлчилгээ үзүүлэх бүх байрлал, тухайн байрлал бүрийн байгууламжийн болон тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл
- (6) Дүрмийн 143.165-д заасны дагуу НТЧ дүгнэх ажилтны жагсаалт
- (7) Дүрмийн 143.167-д заасны дагуу ТҮ-ний хөтөлбөр батлах ажилтны жагсаалт;
- (8) Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах журам;
- (9) НТЧХМБ нь энэхүү дүрмийг хэрхэн дагаж мөрдөхийг тодорхойлсон журам.

143.153 Байгууламж болон тоног төхөөрөмж

(a) НТЧХМБ нь нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн зөвшөөрөгдсөн үйлчилгээнд тохирсон байгууламж, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх ёстой бөгөөд, үүнд

- (1) нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлж буй бүх ажилчдад зориулсан оффисын байр
- (2) энэхүү стандартын шаардлагын дагуу бүртгэл, баримт бичгийг бөглөх, хадгалах байгууламж.

(b) Оффисын байр нь ажилчдын анхаарал сарниулах, таагүй байдал үүсгэхгүйгээр ажил үүргээ гүйцэтгэх орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.

143.155 Гүйцэтгэх захирал

(a) НТЧХМБ нь дараах шаардлага хангагдаж буйг бататгах үүрэг бүхий этгээдийг Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилсон байна:

- (1) тухайн НТЧХМБ –ын үйл ажиллагаа нь энэ Дүрэм, түүний зөвшөөрөл, болон Ерөнхий зааврын дагуу гүйцэтгэгдэх; болон
- (2) НТЧХМБ нь Ерөнхий зааврын дагуу нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээг үзүүлэх хангалттай нөөцтэй байх.

(b) Хэрэв НТЧХМБ нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ (АОС) эзэмшигч бол НТЧХМБ-ын Гүйцэтгэх захирал нь АТ-ийн гэрчилгээний дагуу үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүжүүлэх эрх бүхий этгээд байна.

(c) Хэрэв НТЧХМБ нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ (АОС) эзэмшигч биш бол Гүйцэтгэх захирал нь НТЧХМБ-г удирдах, санхүүжүүлэх эрх бүхий этгээд байна.

143.157 Нөөц

143.159 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер

(a) Хэрэв НТЧХМБ нь АТ-ийн гэрчилгээ эзэмшигч бол, НТЧХМБ нь нислэгт тэнцэх чадвар менежментийн үйлчилгээг энэхүү Дүрэм болон НТЧХМБ -ийн Ерөнхий зааврын шаардлагад нийцүүлэн, АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн эрхийн дагуу үйл ажиллагаа явуулахыг бататгах үүрэгтэй этгээдийг Нислэгт Тэнцэх Чадвар Хадгалалтын Менежерээр томилох ёстой.

(b) Нислэгт тэнцэх чадварын менежер нь Гүйцэтгэх захирал биш # бол НТЧХМБ-ийн Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээнэ.

(c) Энэ бүлгийн (f) хэсэгт харгалзан, нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер тавигдах шаардлага:

(a) агаарын хөлгийн техник үйлчилгээний чиглэлээр наад зах нь дипломын түвшинд мэргэшсэн байх; эсхүл

(b) дараах чиглэлээр наад зах нь нэг мэргэжлээр дипломын түвшинд инженерийн мэргэшилтэй байх

(i) агаарын хөлгийн;

(ii) авионик;

(iii) механик;

(iv) цахилгаан;

(v) электроник.

(d) Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер нь агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар менежментийн чиглэлээр наад зах нь 10 жил ажилласан туршлагатай байх ёстой.

(e) Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер нь дараах зүйлийн талаар мэдлэгтэй байна:

(1) АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн эрхийн дагуу нислэг үйлдэх зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүдийн нислэгт тэнцэхэд хамаарах дүрэм журам, стандарт;

(2) НТЧХМБ-ын Ерөнхий заавар;

(3) Хэрэв боломжтой бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн нислэг үйлдэх зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүдийн нислэгт тэнцэх чадварын нөлөөг тусгасан АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааврын холбогдох хэсгүүд;

(4) НТЧХМБ-ын чанарын систем.

(f) Энэ зүйлийн (c) хэсгийн шаардлагыг үл харгалзан, агаарын тээвэрлэгчийн техник үйлчилгээний хяналт дээр ажиллаж байгаа аливаа этгээд нь, тухайн агаарын тээвэрлэгч НТЧХМБ болох тохиолдолд тухайн НТЧХМБ-ын Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын Менежерээр томилогдох эрхтэй.

(g) НТЧХМБ нь тухайн хүнийг түр эзгүй байх үед Нислэгт Тэнцэх Чадварын Хадгалалтын Менежерийн үүргийг гүйцэтгэж чадах хүнийг орлон гүйцэтгэгчээр томилж болно.

(h) Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер нь мэргэшил, туршлага, мэдлэгтэй холбоотой энэ зүйлийн шаардлагыг хангасан байх ёстой.

(i) НТЧХМБ нь дараах баримт бичгийг хадгална:

(1) Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер болон түүнийг орлон гүйцэтгэгч нь тус бүрдээ энэ ~~жээ~~ зүйлд заасан зохих ур чадвар, туршлага, мэдлэгтэй болохыг нотлох бүх баримт бичгийн хуулбар; болон

(2) Тухайн Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер болон орлон гүйцэтгэгч нар тус албан тушаалаас чөлөөлөгдсөн байсан ч тэдгээрийн бичиг баримтуудын хуулбарыг 2-оос доошгүй жилийн турш хадгалах.

143.161 Чанарын менежер

(a) Чанарын тогтолцоотой байх шаардлагатай НТЧХТБ нь, чанарын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдах үүрэгтэй Чанарын Менежерийг томилох ёстой.

(b) Чанарын менежер нь энэ Дүрэмд заасан үүрэг хариуцлагатай холбоотой асуудлаар Гүйцэтгэх захиралд шууд тайлагнах эрхтэй байна.

(c) Чанарын менежер нь НТЧХТБ -ын Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежер, эсхүл Гүйцэтгэх захирал байж болохгүй.

(d) Чанарын менежер нь дараах шаардлага тавигдана:

(1) НТЧХМБ-ын Ерөнхий зааврын талаархи дэлгэрэнгүй мэдлэг; болон

(2) агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвартай хамаарах дүрэм журам, стандартын талаархи мэдлэг; болон

(3) чанарын удирдлагын чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай.

(e) НТЧХМБ нь дараах баримт бичгийг хадгална:

(1) Чанарын менежер энэ хэсэгт заасан зохих ур чадвар, туршлага, мэдлэгтэй болохыг нотлох бүх баримт бичгийн хуулбар; болон

(2) Чанарын менежер нь тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөн ч түүний баримт бичгийн хуулбарыг 2-оос доошгүй жилийн турш хадгална.

143.162 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн ажилтнууд

НТЧХМБ нь нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн зөвшөөрөгдсөн үйлчилгээг үзүүлэхийн тулд хангалттай тооны зохих мэргэшсэн ажилтнуудтай байна, үүнд:

(1) Дүрмийн 143.165-д заасан НТЧ дүгнэх ажилтнууд; болон

(2) Дүрмийн 143.167-д заасан ТҮ Хөтөлбөрийг батлах ажилтнууд

143.165 Нислэг тэнцэх чадвар дүгнэх ажилтан

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн эрхийн дагуу ашиглагдаж буй агаарын хөлгүүд, эсхүл том оврын агаарын хөлгүүдэд нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг НТЧХМБ нь ИНД-43 -ын дагуу НТЧ шалгалт хийж, гэрчилгээ олгохын тулд НТЧ-ын дүгнэх ажилтнуудтай байх ёстой.

(b) НТЧХМБ-ын нэрийн өмнөөс НТЧ дүгнэлт хийж, гэрчилгээ олгох ажилтан нь НТЧХМБ-аас бичгээр зөвшөөрөгдсөн байх ёстой.

(c) Зөвшөөрөл нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

(1) ажилтны нэр;

(2) зөвшөөрлийн дугаар;

(3) зөвшөөрөл олгосон огноо;

(4) зөвшөөрөл олгосон агаарын хөлгийн маяг, загвар;

- (5) зөвшөөрлийн хамрах хүрээ ба хязгаарлалт;
 (6) зөвшөөрлийн хугацаа (хэрэв байгаа бол).
- (d) НТЧ дүгнэх ажилтан нь:
- (1) нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; эсхүл
 (2) нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж байсан туршлагатай байх эсхүл:
- (i) техник үйлчилгээний В1, В2 эсхүл С ангиллын үнэмлэхтэй; эсхүл
 (ii) В1, В2 эсхүл С ангиллын үнэмлэхтэй дүйцэх зөвшөөрөл
- (f) НТЧ дүгнэх ажилтан нь тухайн ажилтанд зөвшөөрөл олгосон агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварт хамаарах дүрэм журам, стандартын талаар иж бүрэн мэдлэгтэй байх ёстой.
- (g) НТЧ дүгнэх ажилтан нь тухайн ажилтанд зөвшөөрөл олгосон агаарын хөлгийн талаар дараах мэдлэгтэй байх ёстой:
- (1) тухайн агаарын хөлгийн гэрчилгээний үндэслэл;
 (2) ИНД-66 –ээр шаардсан түвшинд, тухайн агаарын хөлгийн бүтэц, систем, хөдөлгүүрийн системийн талаар;
- (h) НТЧХМБ нь Дүрмийн 143.165.(c) хэсэгт дурдсан мэдээллийг агуулсан НТЧ дүгнэх ажилтны жагсаалтыг хөтлөх ёстой.
- (i) НТЧХМБ нь дараах баримт бичгийг хадгална:
- (1) НТЧ дүгнэх ажилтан бүр энэ хэсэгт заасан зохих ур чадвар, туршлага, мэдлэгтэй болохыг нотлох бүх баримт бичгийн хуулбар; болон
 (2) Хуулбаруудыг НТЧ дүгнэх ажилтаны албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 2-оос доошгүй жил хадгална.
- (j) НТЧХМБ нь зөвшөөрлийн хуулбарыг, тухайн зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш, 2 жилийн турш хадгалах ёстой.

143.167 Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах ажилтан

- (a) Энэ Дүрмийн дагуу, агаарын хөлгийн ТҮХ, эсхүл батлагдсан ТҮХ-ийн өөрчлөлтийг хянан батлахаар зөвшөөрөгдөх НТЧХМБ нь, ТҮХ эсхүл батлагдсан ТҮХ-ийн өөрчлөлтийг хянан батлах ажилтнуудтай байна.
- (b) ТҮХ батлах ажилтнууд нь НТЧХМБ-ын нэрийн өмнөөс ТҮХ болон ТҮХ-ийн өөрчлөлтийг батлахын тулд НТЧХМБ -аас бичгээр зөвшөөрөл олгогдсон байна.
- (c) Зөвшөөрөл нь дараах мэдээллийг агуулна:
- (1) ажилтны нэр;
 (2) зөвшөөрлийн дугаар;
 (3) зөвшөөрөл олгосон огноо;
 (4) зөвшөөрөл олгосон агаарын хөлгийн маяг, загвар;
 (5) зөвшөөрлийн хамрах хүрээ ба хязгаарлалт;
 (6) зөвшөөрлийн хугацаа (хэрэв байгаа бол).
- (d) ТҮХ батлах ажилтан нь:
- (1) агаарын хөлгийн инженерийн В1, В2 эсхүл С ангиллын үнэмлэх эзэмшсэн, эсхүл эзэмшиж байсан; эсхүл
 (2) В1, В2 эсхүл С ангиллын үнэмлэхтэй дүйцэх үнэмлэх эзэмшсэн, эсхүл эзэмшиж байсан; эсхүл
 (3) агаарын хөлгийн техник үйлчилгээний чиглэлээр дипломын түвшинд мэргэшсэн байх; эсхүл

- (4) дараахь мэргэжлээр дипломын түвшинд инженерийн мэргэшилтэй байх:
- (i) агаарын тээврийн;
 - (ii) авионик;
 - (iii) механик;
 - (iv) цахилгаан;
 - (v) электроник.
- (е) ТҮХ батлах ажилтан нь тухайн ажилтны зөвшөөрөл авсан агаарын хөлөгтэй ижил буюу ижил маягийн агаарын хөлгийн ТҮХ боловсруулах, удирдах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх ёстой.
- (f) ТҮХ батлах ажилтан нь дараах зүйлийн талаар бүрэн мэдлэгтэй байх ёстой:
- (1) ажилтанд зөвшөөрөл олгосон агаарын хөлгийн ТҮХ-т хамаарах дүрэм журам, стандартууд;
 - (2) хэрэв байгаа бол,
 - (3) хэрэв байгаа бол, агаарын хөлгийн найдвартай байдлын хөтөлбөрт хамаарах дүрэм журам, стандартууд;
 - (4) ажилтны зөвшөөрөл авсан агаарын хөлгийн хувьд, нислэгт тэнцэх чадвар хадгалалтын зааварт тусгагдсан байнгын техник үйлчилгээний шаардлагууд.
- (g) ТҮХ батлах ажилтан нь тухайн ажилтны зөвшөөрөл авсан агаарын хөлгийн байнгын техник үйлчилгээний шаардлагыг боловсруулахад маягийн гэрчилгээ эзэмшигчийн ашигласан техникийн үзүүлэлт, стандартын талаар мэдлэгтэй байх ёстой.
- (h) ТҮХ батлах ажилтан нь тухайн ажилтанд зөвшөөрөл олгосон агаарын хөлгийн талаар дараах мэдлэгтэй байх ёстой:
- (1) тухайн агаарын хөлгийн гэрчилгээний үндэслэл;
 - (2) ИНД-66 –ээр шаардсан түвшинд, тухайн агаарын хөлгийн бүтэц, систем, хөдөлгүүрийн системийн талаар.
- (i) НТЧХМБ нь Дүрмийн 143.167.(с) хэсэгт дурдсан мэдээллийг агуулсан ТҮХ-ийн ажилтнуудын жагсаалтыг хөтлөх ёстой.
- (j) НТЧХМБ нь дараах баримт бичгийг хадгална:
- (1) ТҮХ-ийн ажилтан бүр энэ хэсэгт шаардлагатай зохих ур чадвар, туршлага, мэдлэгтэй болохыг нотлох бүх баримт бичгийн хуулбар; болон
 - (2) ТҮХ ажилтан нь ТҮХ ажилтны албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш бичиг баримтын хуулбарыг 2 –оос доошгүй жил хадгална.
- (k) НТЧХМБ нь зөвшөөрлийн хуулбарыг, тухайн зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш, 2 жилийн турш хадгалах ёстой

143.169 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын зааварчилгаа

- (a) НТЧХМБ нь нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээг үзүүлэхээр зөвшөөрөгдсөн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээний зааварчилгаатай байх ёстой.
- (b) НТЧХМБ нь агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлж буй ажилтан нь түүний үүрэг хариуцлагатай холбоотой нислэгт тэнцэх чадвар хадгалалтын зааварчилгааг авах боломжоор хангагдсан гэдгийг бататгах ёстой.

143.171 Техник үйлчилгээний өгөгдөл

(а) НТЧХМБ нь дараах тохиолдолд аливаа агаарын хөлөг эсхүл нисэхийн бүтээгдэхүүнд тодорхой техник үйлчилгээ хийх шинэ журам, эсхүл одоо байгаа журмын өөрчлөлтийг баталж болно.

- (1) НТЧХМБ-ын нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг агаарын хөлгийн ТҮХ-т тусгагдсан эсхүл тусгах ёстой техник үйлчилгээ; болон
- (2) техник үйлчилгээ хийх журмыг багтаасан техник үйлчилгээний өгөгдөл байхгүй, эсхүл одоо байгаа техник үйлчилгээний өгөгдөл байгаа журам нь тухайн техник үйлчилгээ хийхэд хангалтгүй эсхүл тохиромжгүй; болон
- (3) НТЧХМБ-ын зөвшөөрөл нь тухайн агаарын хөлөг, бүтээгдэхүүний ТҮХ, эсхүл ТҮХ-ийн өөрчлөлтийг батлах боломжийг олгодог; болон
- (4) НТЧХМБ-аас одоо байгаа ТҮ-ний холбогдох өгөгдлийг анхлан үүсгээгүй бол агаарын хөлөг эсхүл нисэхийн бүтээгдэхүүний одоо байгаа ТҮ-ний өгөгдөлд тусгагдсанаас бага хязгаарлалттай гэмтэл, элэгдлийн хязгаарлалт, шалгалт, туршилтын параметруудийг оруулаагүй шинэ журам, эсхүл одоо байгаа журмын өөрчлөлтүүд байх.

(b) Техник үйлчилгээний журмыг ТҮХ эсхүл ТҮХ-т орох өөрчлөлтийн нэг хэсэг гэж үзэн батална.

(c) ТҮ-ний найдвартай ажиллагаа, агаарын хөлгийн нисэх чадамж ба нисэхийн бүтээгдэхүүний ашиглалтад зориулагдсан журамд ТҮ-ний хөтөлбөрийг батлах ажилтан үнэлгээ өгнө гэдгийг НТЧХМБ бататгах ёстой.

(d) НТЧХМБ нь шинэ эсхүл өөрчлөгдсөн журмыг баталгаажуулах ёстой:

- (1) НТЧХМБ -ын үүсгэсэн эсхүл өөрчилсөн техник үйлчилгээний өгөгдөл гэж тодорхой тодорхойлсон; болон
- (2) өгөгдлийн үүсгэсэн эсхүл өөрчилсөн зөвшөөрлийг хянах боломжтой

143.172 Чанарын тогтолцоо

(а) АТ-ийн гэрчилгээний эрхийн дагуу ашиглагдаж буй агаарын хөлөг ба том оврын агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг НТЧХМБ нь дараах шаардлагыг хангасан чанарын системтэй байх ёстой:

- (1) дараах зүйлд хяналт тавих бие даасан аудит хийх:
 - (i) НТЧХМБ нь энэ Дүрэм болон өөрийн Ерөнхий зааварт нийцэж байгаа эсэх; болон
 - (ii) нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээг үзүүлэх НТЧХМБ-ын журмын хангалттай байдал; болон
 - (iii) агаарын хөлөгт хийгдэж буй техник үйлчилгээний стандарт нь ИНД-43-д заасан шаардлагыг хангасан байх; болон
- (2) аудитаар илэрсэн бүх дутагдлыг бүртгэх; болон
- (3) аудитаар илэрсэн дутагдлыг Гүйцэтгэх захиралд тайлагнах; болон
- (4) аудитын дүгнэлтэд илэрсэн аливаа дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх; болон
- (5) хэрэгжүүлсэн засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Чанарын менежерт санал хүсэлт өгөх.

(b) Энэ зүйлийн (а) заалтад заагдсан бүх зүйл 12 сар тутамд нэг удаа шалгаж байх баримтжуулсан төлөвлөгөөний дагуу аудит хийгдэх ёстой.

(c) Аудитыг аудит хийгдэж буй зүйлээс хараат бус, дараах хүмүүс хийх ёстой:

- (1) НТЧХМБ -ын Ерөнхий зааврын талаар бүрэн мэдлэгтэй байх; болон

- (2) агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтад хамаарах дүрэм журам, стандартын талаар мэдлэгтэй байх; болон
- (3) чанарын аудиторын гэрчилгээ авахад шаардагдах сургалтын төрөлтэй дүйцэхүйц чанарын аудитын сургалтыг амжилттай төгссөн.
- (d) НТЧХМБ нь аудитын үр дүнд илэрсэн дутагдалтай холбоотой аливаа засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлэх ёстой.
- (e) НТЧХМБ нь аудиттай холбоотой дараах мэдээллийг агуулсан бүртгэл хөтлөх ёстой:
- (1) аудитын хамрах хүрээ, агуулга;
 - (2) хэзээ аудит хийсэн;
 - (3) аудит хийж байгаа хувь хүн бүрийн мэдээлэл;
 - (4) аудитаар илэрсэн дутагдал;
 - (5) аудитын үр дүнд илэрсэн аливаа дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл.
- (f) Энэ зүйлийн (e) заалтад дурдсан бүртгэлийг аудит хийсэн өдрөөс хойш 2 –оос доошгүй жилийн хугацаанд хадгалах ёстой.

143.173 Дотоод хяналт

- (a) АТ-ийн гэрчилгээний эрхийн дагуу ашиглагдаж байгаа агаарын хөлөг болон том оврын агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг НТЧХМБ нь дараах зүйлийг хийх ёстой:
- (1) Дүрмийн 143.172-д заасны дагуу чанарын тогтолцоотой байх; эсхүл
 - (2) НТЧХМБ нь Ерөнхий заавартайгаа нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд энэ хэсгийн дагуу дотоод хяналт шалгалтыг хийх.
- (b) Хяналт шалгалтыг баримтжуулсан төлөвлөгөөний дагуу хийх ёстой бөгөөд энэ хэсгийн дагуу нягтлан үзэх бүх зүйлийг 12 сар тутамд нэг удаа хянана.
- (c) Хяналтыг дараах шаардлага хангасан этгээд гүйцэтгэнэ:
- (1) НТЧХМБ -ын Ерөнхий зааврын талаар бүрэн мэдлэгтэй байх; болон
 - (2) дараах шаардлагад нийцсэн байна:
 - (i) чанарын аудиторын гэрчилгээ авахад шаардагдах сургалтын төрөлтэй дүйцэхүйц чанарын аудитын сургалтыг амжилттай төгссөн; эсхүл
 - (ii) Агаарын хөлгийн ТҮ-ний байгууллагын дотоод хяналтыг хийж байсан 3 жилийн туршлагатай.
- (d) Хяналтаар илэрсэн дутагдлын бүртгэлийг хөтлөж, Гүйцэтгэх захиралд тайлагнах ёстой
- (e) НТЧХМБ нь шалгалтаар илэрсэн дутагдалтай холбоотой аливаа засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлэх ёстой.
- (f) НТЧХМБ нь хяналт шалгалттай холбоотой дараах мэдээллийг агуулсан бүртгэл хөтлөх ёстой:
- (1) хяналт шалгалтын хамрах хүрээ, агуулга;
 - (2) хяналт шалгалтыг хэзээ хийсэн;
 - (3) хяналт шалгалтыг хийж байгаа хувь хүн бүрийн мэдээлэл;
 - (4) Хяналтаар илэрсэн дутагдлууд;
 - (5) хяналт шалгалтын үр дүнд илэрсэн аливаа дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл
- (g) Энэ зүйлийн (f)–т дурдсан бүртгэлийг дотоод хяналт шалгалт хийсэн өдрөөс хойш 2 –оос доошгүй жилийн хугацаанд хадгалах ёстой.

143.175 Бүртгэл хөтлөх

НТЧХМБ нь энэ Дүрмийн дагуу хөтөлсөн бүртгэлийг хадгалах ёстой:

- (1) бичлэгийг сэргээх боломжтой системд; болон
- (2) бүртгэлийг гэмтээх, санамсаргүй өөрчлөх, алдахаас хамгаалсан байх ёстой.

Е Бүлэг – Батлагдсан найдвартай ажиллагааны хөтөлбөрийн шаардлагууд

143.201 Ерөнхий шаардлагууд

Найдвартай ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) бичгээр байх; ба
- (2) хөтөлбөрт ашигласан аливаа өвөрмөц нэр томъёо, товчилсон үгсийн утгыг тодорхойлох; болон
- (3) дараах зөвшөөрлүүдийн тухай тэмдэглэлийг агуулсан:
 - (i) тухайн хөтөлбөр; болон
 - (ii) тухайн хөтөлбөрийн бүх өөрчлөлтүүд.

143.203 Хөтөлбөрийг тодорхойлох, хэрэглэх боломж

Найдвартай ажиллагааны хөтөлбөр нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) хөтөлбөрөөр хянагддаг агаарын хөлгийн маяг, загвар, серийн дугаар, бүртгэлийн тэмдэг;
- (2) хөтөлбөрөөр хянагддаг агаарын хөлгийн бүртгэлтэй агаарын тээвэрлэгчийн нэр, хаяг;
- (3) хөтөлбөрийг хариуцсан НТЧХМБ-ын нэр, зөвшөөрлийн гэрчилгээний дугаар.

143.205 Хөтөлбөрийн зорилго

- (a) Найдвартай ажиллагааны хөтөлбөрийн зорилгыг хөтөлбөрт тусгасан байх ёстой.
- (b) Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохын тулд нислэгт тэнцэх чадвар хадгалалтын холбогдох зааврыг дагаж мөрдөх ёстой
- (c) Найдвартай ажиллагааны хөтөлбөр нь хамгийн багадаа ТҮХ-ийн ажлуудыг үр дүнтэй гүйцэтгэх, тэдгээрийн үечлэл нь агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтыг хангахад хангалттай байх ёстой.

143.207 Нөөц.

143.209 Өгөгдөл цуглуулах

(a) Найдвартай ажиллагааны хөтөлбөрөөр хянагдаж буй зүйлсийн өгөгдөл цуглуулах системийн тодорхойлолтыг хөтөлбөрт тусгах ёстой. Тодорхойлолт нь дараах зүйлийг агуулсан байх ёстой:

- (1) өгөдлийн эх сурвалжийг тодорхойлох;
- (2) эх сурвалж бүрээс өгөгдөл дамжуулах, хүлээн авах журам;
- (3) эх сурвалжаас дүн шинжилгээ хийх хүртэлх өгөгдөл боловсруулах үе шатууд;
- (4) өгөгдлийг боловсруулах үе шат бүрт байгууллагын үүрэг хариуцлага.

(b) Цуглуулсан өгөгдөл нь дараах шинжтэй байх ёстой:

- (1) үйл ажиллагааны нөхцөлд ажиллаж байгаа зүйлсээс олж авсан; болон

- (2) аливаа дүгнэлтэд итгэх итгэлийг хангах үнэн зөв, бодитой байх; болон
 - (3) гүйцэтгэлийн тогтоосон түвшинтэй шууд холбоотой.
- (c) Мэдээллийн эх сурвалжийн жишээнд дараах зүйлс орно:
- (1) нисгэгчийн илтгэлүүд;
 - (2) төлөвлөгөөт бус буулгалт;
 - (3) хянагдсан эвдрэл гэмтэл
 - (4) жишээ болгон хийсэн үзлэг;
 - (5) үйлчилгээний цех/тасгаас илрүүлсэн дутагдлууд
 - (6) ажиллагааны шалгалт;
 - (7) суурийн төхөөрөмж дээр шалгах.

143.211 Гүйцэтгэлийн стандартууд

(a) Найдвартай ажиллагааны хөтөлбөр нь тухайн зүйлийн найдвартай ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөх түвшинг тодорхойлсон хөтөлбөрт хамрагдсан зүйл бүрийн хувьд математикийн хэллэгээр илэрхийлсэн гүйцэтгэлийн стандартыг агуулсан байх ёстой. Түгээмэл хэрэглэгддэг гүйцэтгэлийн стандартуудын зарим нь дараах байдалтай байна:

- (1) эд зүйлсийг хугацаанаас нь өмнө буулгах хувь хэмжээ;
 - (2) эд зүйлсийн хянагдсан эвдрэл гэмтлийн хувь хэмжээ;
 - (3) нислэгийн үед хөдөлгүүр унтрах хувь хэмжээ;
 - (4) аливаа зүйлийн гэмтэл, доголдлын улмаас нислэгийн саатал, цуцлалтын хувь хэмжээ;
 - (5) эд анги шингэнээ дотуур алдах хувь хэмжээ.
- (b) Гүйцэтгэлийн стандартыг илэрхийлэхийн тулд дээд ба доод хязгаарыг ашиглаж болно. Энэ нь найдвартай ажиллагааг тайлбарлах найдвартай ажиллагааны зурвас буюу хүрээг илэрхийлнэ.
- (c) Хөтөлбөр нь гүйцэтгэлийн стандартыг бий болгоход ашиглах арга, өгөгдлийг тайлбарлах ёстой.
- (d) Гүйцэтгэлийн стандарт нь хариу үйлдэл үзүүлж болохуйц бөгөөд найдвартай ажиллагааны түвшинд мэдрэг байх ёстой. Энэ нь хэвийн бус өөрчлөлтүүд сэрэмжлүүлэг өгөөд байхаар өндөр байх шаардлагагүй, эсхүл хэт нам байж тэдгээр нь засч залруулах арга хэмжээнээс тогтмол хэтэрсэн байж болохгүй.
- (e) Гүйцэтгэлийн стандартууд нь Дүрмийн 143.211.(f) -т дурдсан үл хамаарал бүхий тээвэрлэгчийн өөрийн үйл ажиллагааны туршлагад үндэслэсэн байх ёстой. Туршлагын хугацаа нь өмчлөлийн буюу хяналтанд байгаа агаарын хөлгийн парк ашиглалт, хэрэглээнээс хамаарна.
- (f) Хэрэв тээвэрлэгчид агаарын хөлгийн маяг, загварын ашиглалтын туршлага байхгүй эсхүл хязгаарлагдмал бол гүйцэтгэлийн стандартыг дараах зүйлсээс 1 ба түүнээс дээш зүйлд үндэслэн тогтоож болно.
- (1) бусад операторуудын ижил маягийн эсхүл загварын агаарын хөлгийн ашиглалтын туршлага
 - (2) операторын өөрийн ижил маягийн эсхүл загварын агаарын хөлгийн ашиглалтын туршлага
 - (3) өөр маягийн агаарын хөлөг дээрх ижил төрлийн бүтээгдэхүүн эсхүл системийн ажиллагаа
 - (4) агаарын хөлгийн дизайнд ашигласан ашиглалтын үеийн найдвартай ажиллагааны хүлээгдэж буй үр дүн.
- (g) Хөтөлбөр нь үйл ажиллагааны туршлага, бүтээгдэхүүний сайжруулалт, журмын өөрчлөлтийг тусгахын тулд гүйцэтгэлийн стандартыг тогтмол хугацаанд хянах, дүгнэх журмыг агуулсан байх ёстой.

(h) Хөтөлбөр нь Дүрмийн 143.211.(f) ~~хэсгийн~~ заалтын дагуу тогтоосон гүйцэтгэлийн стандартыг оператор нь үйл ажиллагааны хангалттай туршлага хуримтлуулсны дараа хянан үзэхээр хангасан байх ёстой.

143.213 Мэдээллийг харуулах

- (a) Найдвартай ажиллагааны хөтөлбөр нь чиг хандлага, үйл явдал, гүйцэтгэлийн стандартаас хэтэрсэн тохиолдолд хялбар тодорхойлох боломжийг харуулах форматыг хангах ёстой.
- (b) Харуулах мэдээлэл нь график, хүснэгт хэлбэрээр эсхүл хоёуланг нь хослуулсан байж болно
- (c) Харуулахын өмнө мэдээллийг салгах, устгах зохицуулалтыг хөтөлбөрт тусгасан байх ёстой.

143.215 Мэдээллийн дүн шинжилгээ, тайлбар

- (a) Найдвартай ажиллагааны хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр үүссэн мэдээллийн тогтмол дүн шинжилгээ, тайлбарыг хангах ёстой.
- (b) Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлбарлах аргыг хөтөлбөрт тайлбарласан байна.
- (c) Ашигласан аргууд нь заавал дараах хэлбэртэй байх ёстой:
- (1) хөтөлбөрийн хяналтанд байгаа зүйлсийн гүйцэтгэлийг хэмжих боломтой; болон
 - (2) онцлох асуудлуудыг таних, оношлох, бүртгэх ажлыг хөнгөвчлөх

143.219 Шинжлэн шалгах, залруулах арга хэмжээ

- (a) Хөтөлбөр нь гүйцэтгэлийн стандартыг хэтрүүлсэн тохиолдолд идэвхтэй шинжлэн шалгах, шаардлагатай бол засч залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тусгасан байх ёстой
- (b) Гүйцэтгэлийн стандартыг илэрхийлэхийн тулд дээд ба доод хязгаарыг ашигладаг бол хязгаар тус бүрийн дагаж мөрдөх шаардлагыг хөтөлбөрт бүрэн тусгасан байх ёстой.
- (c) Залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, залруулах арга хэмжээний үр нөлөөг хянах журмыг хөтөлбөрт тусгасан байх ёстой.
- (d) Гүйцэтгэл хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрэх хүртэл засч залруулах арга хэмжээг хариуцаж буй хүнд хуваарийн дагуу мэдээлэл хүргүүлэх тухай журамд тусгагдсан байх ёстой.
- (e) Залруулах арга хэмжээ нь хөтөлбөрөөс илэрсэн найдвартай ажиллагааны аливаа бууралтыг засах ёстой бөгөөд дараах 1 ба түүнээс дээш хэлбэрийг агуулж болно:
- (1) техник үйлчилгээ, үйл ажиллагааны журам эсхүл техникт гарсан өөрчлөлт;
 - (2) ажлыг нэмэгдүүлэх, багасгах, ажлыг нэмэх, өөрчлөх, устгах зэрэг техник үйлчилгээний хөтөлбөрийн ажилд өөрчлөлт оруулах;
 - (3) нийт агаарын хөлгүүдэд хийгдэх нэг удаагийн тусгай техник үйлчилгээ;
 - (4) агаарын хөлөг болон нисэхийн бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлэх;
 - (5) техник үйлчилгээ хийх сэлбэг хэрэгслийн нөөцийн өөрчлөлт;
 - (6) техник үйлчилгээ хийх хүн хүч, тоног төхөөрөмжийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах;
 - (7) техник үйлчилгээний ажилтнуудыг сургах.
- (f) Боломжтой бол засч залруулах арга хэмжээ бүр нь төлөвлөсөн, дуусгах огноог агуулсан байх ёстой.

143.221 Хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт

- (a) Найдвартай ажиллагааны хөтөлбөр нь хөтөлбөрийн үр нөлөөг бүхэлд нь тасралтгүй хянах, энэ -хяналтыг хариуцах хувь хүн бүрийг тодорхойлох ёстой.
- (b) Хөтөлбөр нь хөтөлбөрт өөрчлөлт оруулах журмыг агуулсан байх ёстой бөгөөд өөрчлөлтийг санал болгох, бэлтгэх үүрэгтэй этгээдийг тодорхойлох ёстой.

143.223 Өгөгдлийг нэгтгэх

- (a) Жижиг агаарын хөлгийн флотын найдвартай ажиллагааны хөтөлбөрийн хувьд өгөгдлийг "цөөрүүлэх", өөрөөр хэлбэл ижил маягийн агаарын хөлгийн хэд хэдэн операторын өгөгдлийг нэгтгэхийг зөвшөөрдөг.
- (b) Энэ хэсгийн хувьд жижиг нисэх онгоцны флот нь ижил маягийн 6-аас бага нисэх онгоцтой флот юм.
- (c) Шинжилгээ хүчинтэй байхын тулд өгөгдөл цуглуулсан агаарын хөлгийн хувьд дараах зүйлс үндсэндээ ижил байх ёстой:
- (1) агаарын хөлгийн тохиргоо;
 - (2) агаарын хөлгийн нас, ашиглалтын түвшин;
 - (3) үйл ажиллагааны төрөл, үйл ажиллагааны орчин;
 - (4) ТҮХ, Техник үйлчилгээний журам.
- (d) Хөтөлбөр нь нэгтгэх зохион байгуулалт, нэгтгэх өгөгдлийн төрөл, хэмжээг тодорхойлсон байх ёстой.

F Бүлэг - Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн байгууллагуудад тавигдах шаардлага, зөрчил**143.301 Нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээний нөхцөл**

- (a) Хэрэв НТЧХМБ нь нислэгт тэнцэх чадвар хадгалалтын менежментийн үйлчилгээ үзүүлж байгаа бол зөвхөн дараах зүйлийн дагуу үйлчилгээ үзүүлэх ёстой:
- (1) өөрийн Ерөнхий заавар; болон
 - (2) зөвшөөрөлд хамаарах аливаа хязгаарлалт болон түүний зөвшөөрөл

- (b) Энэ зүйлийн (a) заалтыг мөрдөхгүй байх нь хатуу хариуцлагатай зөрчил юм

143.303 Ажилтнуудыг Ерөнхий заавраар хангах

- (a) Хэрэв НТЧХМБ-ын Ерөнхий заавар нь тухайн байгууллагын ажилтны үүрэг хариуцлагатай холбоотой бол тус ажилтан үүргээ гүйцэтгэж эхлэхээс өмнө байгууллагын Ерөнхий зааврын эдгээр үүрэгт хамаарах хэсгийг ажилтанд нээлттэй болгох ёстой.

- (b) Энэ зүйлийн (a) заалтыг мөрдөхгүй байх нь хатуу хариуцлагатай зөрчил юм.

143.307 Зааврыг дагаж мөрдөх

- (a) Хэрэв Дарга НТЧХМБ-д Дүрмийн 143.107-д заасны дагуу зааварчилгаа өгсөн бол тухайн байгууллага зааварчилгаанд заасан хугацаанд тус зааварчилгааг биелүүлэх ёстой.

- (b) Энэ зүйлийн (a) заалтыг мөрдөхгүй байх нь хатуу хариуцлагатай зөрчил юм.

143.309 Гэрээний дагуу мэдээлэл өгөх

Хэрэв:

- (1) НТЧХМБ нь бүртгэлтэй агаарын тээвэрлэгчтэй гэрээ байгуулсан; болон
- (2) тухайн байгууллага нь тухайн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалалтын талаар мэдээлэлтэй байна;

Байгууллага нь тухайн гэрээний дагуу бүртгэлтэй агаарын тээвэрлэгчид мэдээлэл өгөх ёстой.

143.311 Дүрмийг зөрчсөн тухай мэдэгдлийг Даргад хүргүүлэх

(a) Хэрэв:

- (1) НТЧХМБ нь бүртгэлтэй агаарын тээвэрлэгчтэй гэрээ байгуулсан; болон
- (2) тухайн агаарын тээвэрлэгч энэ Дүрмийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй бол

Байгууллага нь зөрчил гарсан гэж үзсэнээс хойш 7 хоногийн дотор тухайн байгууллага зөрчлийн талаар Даргад бичгээр мэдэгдэх ёстой.

(b) Гэсэн хэдий ч:

- (1) тухайн мэдэгдэл доторх мэдээлэл; эсхүл
- (2) тухайн мэдэгдэл доторх шууд болон шууд бусаар олж авсан аливаа мэдээлэл, баримт бичиг, эсхүл эд зүйлсийг

эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тухайн хүний эсрэг нотлох баримт ~~гэж~~ болгон ашиглахгүй.

--oOo--